



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 41

Алтай

Цэргийн дүйцүүлэх албанд оруулах  
иргэдийн тооны хязгаар батлах тухай

Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйл, Засгийн газрын 2017 оны 51 дүгээр тогтоол, Цэргийн албыг дүйцүүлэн хаах журмын 6 дугаар хэсгийн 19-ийн А дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Тус аймгаас 2017 онд цэргийн дүйцүүлэх албанд /татагдах/ хамрагдах иргэдийн тоог 40 хүнээр тогтоож хавсралтаар баталсугай.

2. “Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам”-ыг үндэслэн иргэдийг элсүүлэх, цугларалт, сургалт явуулах, орон нутгийн бүтээн байгуулалтын ажил болон онцгой нөхцөл байдлын үед дайчлах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/, Цэргийн штабын дарга /М.Батсуурь/ нарт даалгасугай.

3. Цэргийн дүйцүүлэх албанд иргэдийг элсүүлэх ажлыг ил тод нээлттэй явуулж, иргэд олон нийтэд сурталчилж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д үүрэг болгосугай

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүдэгчдийн  
2017 оны 05 дугаар сарын 22-ны  
өдрийн 41 дугаар тогтоолын  
хавсралт



Цэргийн дүйцүүлэх албанд оруулах  
иргэдийн тооны хязгаар

| №  | Сум       | Хамрагдах хүний тоо | Тайлбар |
|----|-----------|---------------------|---------|
| 1  | Алтай     | 3                   |         |
| 2  | Баян-Уул  | 2                   |         |
| 3  | Бугат     | 3                   |         |
| 4  | Дарив     | 3                   |         |
| 5  | Дэлгэр    | 2                   |         |
| 6  | Тайшир    | 2                   |         |
| 7  | Тонхил    | 3                   |         |
| 8  | Төгрөг    | 2                   |         |
| 9  | Хөхморьт  | 3                   |         |
| 10 | Халиун    | 1                   |         |
| 11 | Эрдэнэ    | 3                   |         |
| 12 | Цогт      | 3                   |         |
| 13 | Есөнбулаг | 10                  |         |
| 14 | Дүн       | 40                  |         |